

МОНГОЛ ЦЭРГИЙН ХӨГЖМИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Ш.Цогтгэрэл.

Батлан Хамгаалахын Их сургууль. Цэргийн хөгжмийн сургууль

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд цэргийн хөгжмийг монголчууд Нийтийн тооллын өмнөх үед ч цэрэг, дайны үйл ажиллагаандаа хэрэглэж ирсэн тухай болон ялангуяа Их Монгол улсын үед цэрэг дайны ажиллагаандаа үлээвэр болон цохивор хөгжмийн зэмсгүүдийг өргөн ашиглаж ирсэн тухай түүний онцлог, ач холбогдолын талаар тодруулж түүхийн судалгааны чиглэлд тулгуурлан эрдэм шинжилгээ-судалгааны ажлын эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байгааг баримтад түшиглэн өгүүлсэн болно.

Түлхүүр үг. Дуу хөгжим, цэрэг дайны хөгжим, цэргийн жанжин, цэргийн хөгжмийн зэмсэг, үлээвэр болон цохивор хөгжим,

Дэлхийн улс үндэстнүүд олон зуун жилийн туршид дайн тулааны үед ч, тайван цагт ч “Цэргийн хөгжим”-ийг чухал хэрэглүүр болгон ашиглаж иржээ. Учир нь ерөөс урлаг хэмээх зүйл, түүний дотор хөгжмийн урлаг нь хүмүүсийн оюун сэтгэхүйд ихээхэн нөлөөтэй байдагтай холбоотой. Хөгжим нь хүнд оюун санаа, гоо сайхны өндөр хэмжээний сэрэл мэдрэхүй, таашаалыг төрүүлэхээс гадна шинжлэх ухааны нэгэн адил мэдлэг ухааныг ч өгч чаддаг хэрэглэгдэхүүн болой. Хөгжим ийнхүү хүмүүсийн оюун сэтгэхүйд хүчтэй нөлөөлж, хүний зүрх сэтгэлд гайхалтай мэдрэмжийг төрүүлэгч увидастай учраас нэрт цэргийн жанжинууд, авъяаслаг удирдагчид хөгжмийн ид шидийг ашиглаж, энэ олон зууны туршид улс гүрнүүдийн доторхи том, жижиг дайн тулаан, дэлхийн олон орныг хамарсан аугаа их байлдан дагуулалтын үед ч цэргийн хөгжмийг ашигласаар иржээ.

Хөгжим бол хүний оюун сэтгэлийн илэрхийлэл. Оросын нэрт хөгжмийн зохиолч Д.Д.Шостакович **“Хөгжим танд агуу их сэрэл, хүсэл сэтгэлгээний ертөнцийг нээж таны оюун санааг баялаг, цэвэр төгөлдөр болгоно. Хөгжмийн ачаар та өөртөө урьд байгаагүй асар их хүчийг олж харна”** [1.157] гэж хэлсэн байдаг нь ч үүний баталгаа. Үнэхээр ч хөгжмийн ачаар хүн өөртөө урьд байгаагүй их хүчийг олж авдаг гэдгийг цэргийн жанжнууд олон зуун жилийн өмнө мэдэрч, тулалдааны үеийн сахилга бат, өндөр ёс суртахуун, зүрх зоригийг хөгжимтэй холбож, онцгой ач холбогдол өгч иржээ.

Жишээ нь Наполеон Бонапарт **“Оростой байлдахад манай цэргүүдэд хоёр л том дайсан байсан. Нэг нь Оросын хүйтэн өвөл, нөгөө нь оросын цэргийн хөгжим”** [2] гэж нэгэнтээ хэлсэн бол Оросын цэргийн гарамгай жанжин А.В.Суворов **“Би Измаилыг чанга сүрлэг дуутай хөгжим, намирсан тугтай эзлэн авч байсан. Цэргийн хөгжим нь армийн сүр хүчийг 2-3 дахин нэмдэг”** [3.30] гэж хэлсэн нь түүний бас нэг нотолгоо.

Манай монголчууд хөгжмийн тэр их увидасыг хэнээс ч дутахгүй мэдэрч байсан тул олон мянган жилийн туршид, түүхийн янз бүрийн цаг үед, цэрэг армийн үйл ажиллагаандаа мөн л хөгжмийг хэрэглэсээр иржээ.

Монголчууд хөгжмийн өндөр соёлтой байсныг, энэ нь олон мянган жилийн түүх цадигтайг эх сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн баримт сэлтээс гадна гадаад, дотоодын эрдэмтдийн бичсэн эрдэм шинжилгээний бүтээл, жуулчдын тэмдэглэл, дүрслэх урлагийн дурсгал, ургын дуу, шүлэг гэх мэт олон зүйл нотолж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар зарлигийн дагуу туурвисан “Монгол Улсын түүх”-ийн тэргүүн ботид Монгол оронд хүн анх 800000 жилийн тэртээгээс нутаглаж ирсэн бөгөөд дээд палеолитийн /НТӨ 40000-15000 жил/ буюу хуучин чулуун зэвсгийн үед урлаг үүссэн болохыг нотолжээ. Харин хөгжим яг тэр үед үүсжээ гэдгийг одоогоор хараахан тогтоож чадаагүй байгаа ч нэгэнт дээд

палеолигийн үед урлаг үүссэн гэдэг нь илт тул хөгжим түүнээс өмнө үүссэн байхыг ч үгүйсгэх аргагүй юм.

Мен археологичид эртний судлалын зарим баримт, тодруулбал шавраар хийсэн аяга хэлбэртэй савны хажуу болон дотор талын зурагт нэн эрт үеийн хүмүүсийн нийтээрээ дуулж бүжиглэн хөгжимдөж буй хөдөлгөөнт дүрслэлүүд байгааг судлан шинжээд энэ нь Палеолитийн үед хамрагдаж буйг нотолсон байна. [4.55] Ийнхүү дуу хөгжмийн урлаг, түүний дотор цэргийн хөгжим олон мянган жилийн өмнө үүссэн болох нь батлагдаж байна.

Бөөгийн шашин, шарын шашин хоёрыг эрт цагаас эхлэн голлон шүтэж ирсэн монголчууд эдгээр шашны үйл ажиллагаандаа хөгжмийн зэмсгийг уламжлан авч ирсэн нь түүний наад захын жишээ бөгөөд шашны уламжлалт зан үйлд цохивор болон үлээвэр хөгжмийг голлон хэрэглэдэг байсан нь өнөөдөр ч хэвээр хадгалагдан үлджээ.

Манай үндэсний дуу, хөгжим, эх нутаг, газар дэлхий, амьдрал ахуйтайгаа нягт уялдаа холбоотой агаад эхтэй. Тиймээс ч хөгжмийн гарал үүсэлтэй холбоотой "...хэнгэрэг буюу бөмбөрийн анх луу болон тэнгэрийн дууг дууриалган хийсэнд аалз мэтийн амьтан заримдаа эндүүрдэг юм гэнэ билээ...", бар арслангийн дууг дууриалгасан авиа чимээ гаргах зорилгоор монгол дэрхчууд гуулинд олон зүйлийн хольц хийж найруулсаар байгаад харанга хөгжмийг хийсэн... бишгүүрийг галиванга шувууны дууг дууриалган хийсэн..." [5.5] гэх мэтчилэн домог яриа олон бий. Эдгээр домгийн зарим нь үнэний хувьтай байхыг ч үгүйсгэх аргагүй. Үү нь монголчуудын үлээвэр хөгжмийн зэмсгүүд нь тарваганы хошгиороо, зурамны шогшроо, бугын дуудлага, чоно үнэг зэрэг араатан амьтны улих, хуцах, жигүүртэн шувуудын жиргэх, гуаглах, донгодох зэрэг олон зүйлийн авиаг дууриалган дуу авиа үүсгэхээр үйлдсэн өнөөгийн шүтэл, эвэр бүрээ зэрэгтэй төсөөтэй дуу авианы хэрэгслээс анх үүссэн нь илэрхий байдаг.

Монгол нутгаас 1-3 нүхтэй ясан шүтэл, хэнгэрэг, дамар олдсон нь одоогоор мэдэгдээд буй хөгжмийн зэмсгийн хамгийн эртнийх нь болж байгаа бөгөөд хадны зургуудад ч эрт балрын үеийн хөгжим хийгээд бүжиг наадмыг дүрсэлсэн баримт олноор хадгалагдан үлджээ. [6.245] Энэ бүх дуу авианы хэрэгсэл нь аажимдаа ардын ая дуунд хадгалагдан, язгуур зориулалт, хэлбэр дүрсээ өөрчилж жинхэнэ хөгжмийн зэмсэг болон хөгжсөн байна.

Монголчууд дайн тулааны үед хөгжмийн зэмсгийг хэрэглэж байсан тухай одоогоор мэдэгдэж буй ихэнх мэдээ баримт нь Хүннү улс хүчирхэгжин мандсан үетэй холбоотой байна. Монголчуудын эртний өвөг болох Хүннү нар үлээвэр, чавхдаст, цохивор гэх мэт олон төрлийн хөгжмийн зэмсэг хэрэглэдэг байсан нь олон зүйлээр батлагджээ. Жишээ нь, Нийтийн тооллын өмнөх 100 дугаар онд холбогдох нэгэн хятад сурвалжид: "...Хятадын Хан улсын үед монголчуудын өвөг болох Хүннү нарыг "Зүүдний хүү" гэдэг хаан толгойлж байжээ. Тэр үед Хятадын Хан улсын цэргийн хоёр эрхтэн баригдан хоригджээ. Түүний нэгийг Ли Лин, нөгөөг нь Сүн-Ү гэдэг байжээ. Байлдааны хэргийг ерөнхийлж байсан Ли-Линг Енисей мөрөн, Абакан гол хоёрын бэлчрээр нутаглуулж, харин Су Ү нь Байгал далайн дэргэд яма хариулж байжээ. Тэр хоёр хоорондоо захидлаар харилцаж байсан ба Сүн-Ү-гийн захианд "Пөнөдөө Хүннүгийн хөдөө хязгаарт суухад үргэлж Хүннү цэргийн бүрээний дуу миний чихээр ороод зүрхийг имчнээ" [7.135] гэсэн байна.

Эртний судлалын баримтуудад дурьдснаар Нийтийн тооллын өмнө буюу одоогоос олон мянган жилийн өмнө монголчууд лимбэ, хөндлөн бишгүүр, бүрээ зэрэг үлээвэр хөгжмийн зэмсгийг өргөн хэрэглэж байсан нь тодорхой байдаг. Хүннү нарт цохивор хөгжмийн зэмсгээс хэнгэрэг, чавхдаст хөгжмөөс кунхоу /хуур/, чавхдаст товшвороос бийбаа, үзэврээс цуур, лимбэ, хөндлөн бишгүүр зэрэг нилээд олон төрлийн хөгжмийн зэмсгүүд байсныг эрдэмтэд нотолсон. [8.32]

Ийнхүү Монголчууд нийтийн тооллын өмнөх хэдэн зууны тэртээгээс цэргийн бүрээ, лимбэ зэрг үлээвэр хөгжмийн зэмсгийг бүтээн хэрэглэж байсан бол Хүннүгийн дараа нийтийн тооллын I-III зуунд Монгол нутагт төр улсаа байгуулсан "Сяньбичүүд дуу хөгжимд их дуртай, бүжиг наадам хийдэг, зарим үед хааныхаа ордонд 80 төрлийн

хөгжмийн зэмсэг оролцсон чуулга тоглуулдаг байснаас гадна төрийн ёслол, цэрэг гарах, буух, анд мордох үед болон хааны ордонд ямар дуу дуулах, ямар хөгжимтэй байлгах тухай тусгайлсан хэв журмыг тогтоож байжээ” [9.108].

Мөн “VIII-IX зууны үед буюу Уйгарын засаглалын үед найр наадам их хийж, дуулж бүжиглэхдээ гарамгай байсан гэх бөгөөд бусад нүүдэлчин улсын адил өөрийн нутгийн хөгжмийн зэмсгээс гадна зах нийлэх улсын ордны цэнгээнд хэрэглэдэг хөгжмийн зэмсгийг захиалан авч хэрэглэдэг байсан бол VIII-XI зууны үед хүчирхэгжин мандаж байсан Киданчууд хасын хөндлөн бишгүүр, пи-па, байлдааны хэнгэрэг зэрэг хөгжимтэй, мөн “Бишгүүрийн эзэн” хэмээх тушаалтан, бас дуучны бүлэгтэй байсан [10.12] мэдээ бий.

Нийтийн тооллын 208 оны үед Нанхиадаас хулгайлагдан ирж нүүдэлчин монголчуудын дунд аж төрж байсан Гүн гэрийн хатагтай /Гүн гэрийн хатагтай гэдэг нь удам залгасан ордны бичгийн мэргэн бүсгүйг нэрлэх бөгөөд эл хатагтайн жинхэнэ нэрийг Иен гэх ба бичгийн өргөмжлөлт нэр нь Цай овгийн Вэн Жи буюу соёлт бүсгүй гэсэн утгатай үг ажээ/-н зохиосон “Нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу” хэмээх дуу хөгжим, яруу найргийн цомогт:

“...Гүн шөнөөр Су-Во-гийн биба

Би чиу-гийн лимбэ

Уйтгартай сонсогдоно... /Су-Во-Байгал далайн эргээр нутаглах нүүдэлчид, Би-бачавхдаст товшуур хөгжмийн зэмсэг, Би чиу-тэр цагийн үндэстний нэр/” [11.40,42] гэх мэт нүүдэлчдийн дунд дуурьсаж байсан хэнгэрэг, бүрээний дуу, модон цуур, ятга, бялар, бишгүүрийн дуу аялгуу, чавхдаст товшуур, үлээвэр, цохивор зэрэг хөгжмийн зэмсгүүдийн талаар бодитой олон мэдээ тусгагджээ.

XIII зууны буюу Их Монгол Улсын үеийн дуу, хөгжмийн урлагийн талаар манай эрдэмтэн судлаачид баримтад тулгуурласан, таамаглал дэвшүүлсэн эрдэм шинжилгээний олон бүтээл туурвисан байна.

Нэгэн сурвалжид Чингис хаан Тангуд улсыг төвшитгөсний дараа Өгөдэй хааны хүү Гүег нэгэн багласан бишгүүрийг олоод “Үүнийг дуугаргаж чадах хүн байваас түүнийг шагнана” хэмээн зарлал буулгасанд Гау Юе Юу хэмээх хүн ирж “Миний бие бичгийн хэрэг эрхэлдэг тул аялгуу хөгийн хэргийг нилээд мэднэ. Одоо улс орон батжиж байгаа тул яруу хөгжмийг засваас зохино...” хэмээснийг хаан зөвшөөрч эзлэгдсэн улсын хөгжмийг татаж хэрэглэсэн [12.9,10] гэх ба түүнээс үзвэл тэр үеэс бишгүүрийг хэрэглэх болсон байж болзошгүй бөгөөд “яруу хөгжмийг засваас зохино” гэснийг үзвэл бас өөр олон төрлийн хөгжмийн зэмсэг байсан нь ч илт байна.

Марко Поло-гийн тэмдэглэл дэх “Наяны тэрслэн хөдөлсөн” гэдэг хэсэгт “...Тэд байлдааны их хэнгэрэг дуугарахаас нааш тулалдаанд ордоггүй бөгөөд энэ зуур бүгд хөгжимдөн дуулцгаадаг. Тэгээд хэнгэрэг дэлдэхэд хашгиралдан дайрна” [13.88] хэмээн тэмдэглэжээ. Эндээс үзэхэд Чингис хааны цэрэг дайчид хөгжим эгшиглэхэд жагсаалаа тэгшитгэж, мөн хөгжмийн эгшгээр /байлдааны хэнгэрэг дэлдэхэд/ довтолгоонд орж байжээ гэж ойлгогдоно.

Ер нь бүрээ, бишгүүр, хэнгэрэг, хүүрэг тэргүүтэн хөгжмийн зэмсгүүд нь дайн байлдааны үед цэргийн удирдлагын гол хэрэгслийн нэг болж байсан нь олон зүйлээр батлагдана.

Дундад эртний үеийн Япон, Хятад, Персийн зураачдын бүтээлд тэр үеийн монгол цэргийн хөгжмийн зэмсгүүдийг тод томруун дүрсэлсэн байдаг. Энэ бүхэн нь дайн тулааны үед цэргийн хөгжим нь ямар чухал үүрэгтэй байдгийн нэгэн баталгаа юм. Мөн монголчууд цэрэг дайны үйл ажиллагаандаа хөгжмийн зэмсгийг хэрхэн хэрэглэж байсан баримт болохоос гадна тухайн зэмсгийн бүтэц хийц, хөгжимдөх арга хэлбэрийг тодотгож өгч байгаагаараа судалгааны чухал баримт болж байна.

Сурвалж зургийн дурсгалаас гадна, XIII-XIV зууны **бүрээ, царгил, нумт хуур** буюу “Аман хил” зэрэг хөгжмийн хийц бүтэц ямархуу байсныг харуулах биет баримт ч Их

Монгол улсын уугуул газар нутагт өнөөг хүртэл уламжлагдан хадгалагдсаар ирсэн нь бий. Үүний нэг нь одоо Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутаг “Чингисийн онгон”-д “Чингис хааны догшин хар сүлд”-ийн хамт хадгалагдаж, тайлга тахилгад нь шиглагдсаар буй “Хашгираа ихт хатан улаан бураа буюу бүрээ”, мөн царги /царгил/ хэмэх эртний хөгжмийн зэмсгүүд юм. Тэрхүү бүрээг зандан модоор хийсэн байх бөгөөд уртааш нь залгадаг хоёр хэсгээс бүрддэг, хэсэг бүр 3 мөнгөн бүслүүртэй, одоогийн буддын шашны сүм хийдэд хэрэглэдэг их гуулин бүрээнээс нарийн бөгөөд арай богино, мөнгөн бурзантай, дуу нь “тэнгэрийн мянган луу дуугарах мэт хүчтэй, сүрлэг тул дайсан этгээд сонсмгц манаран унадаг” [14.44] гэх домогтой ажээ.

Царги буюу царгил нь нэгэн төрлийн цохивор хөгжмийн зэмсэг бөгөөд морин толгойтой, 1. нарийн ялтас модыг хэлхэж хийсэн байна. 12 эгшигтний журмаар хэлхсэн ч гэж ярьдаг. Хар сүлдийг догшруулах тайлгын үед сүлдийн өчиг өчсөний дараа тэнгэрт хандсан “тэнгэрийн 12 дуу”-г дуулах үед тэрхүү царигийг дэлдэж сүр хүчийг нь бадраадаг ажээ.

Цэргийг хөгжмийн зэмсгээ монголчууд бас байлдах зэвсгээсээ үлгэрлэн хуулбарлаж хийсэн нь ч байдаг. Үүний нэг нь нумт хуур юм. Судлаач Ж.Бадраа “Аман хил” [15.153] гэж бас нэрийг нь судар бичгээс хөөн тодотгосон байна. Уг хөгжим нь монгол цэргийн нум мэт хэлбэртэй, өөрөөр хэлбэл нумарсан их бие, хөвч, цохиураас бүрддэг, хөгжимдөхдөө нумын нэг хчир буюу үзүүрийг зөөлөн зууж хуруугаар юмуу цохиураар /нум сумын бол сум гэсэн үг/товшин цуурайтуулж эгшиглүүлдэг.

Нумт хуур нь эртний монгол цэргийн хэвтүүл, харуулууд шөнийн цагаар манаа, туршуулын үрэг гүйцэтгэж байхдаа өөрийн гол зэвсэг болох нум сумыг ашиглан дээр дурьдсанчлаа хөвчийг нь сумаар цохин доргиож олон төрлийн ая эгшиг /авиа/ гарган бие биедээ дохисогддог байснаас үүдсэн гэдэг домог ч байдаг ажээ [16].

Хөгжмийн зэмсэг, хөгжмийн соёл нь XIII зууны үеэс монголд улам бүр боловсорч зовхон цэрэгдэйн төдийгүй төрийн ёслол хийгээд эгэл ахуйд гүн нэвтэрч, төрөл зүйл нь олширч, ая эг нь ч олон хэлбэр маягтай болжээ. Түүний дотор үлээвэр болон цохивор хөгжмийн зэмсэг илүүтэй чухал үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхой байна. Тэдгээр нь хөгжмийн аягууг илүү сүрлэг хүчтэй болгож өгдөг бөгөөд энэ нь эр хүн бүр бараг толгой дараалан цэрг болдог байсан дайчин амьдрал ахуйд зохицсон, тэдний сэтгэл зоригийг чангалах увцастай байсан гэж ойлгогдож байна. Мөн цэрэг эрсийн хахир хатуу амьдралд, тэр тусмаа “цусан далай” давалгаалсан урт холын аянд сэтгэлийн чилээг гаргах гол хэрэгсэл нь дуу, хөгжим болдог байсан учир эртний монголын хаан, ноёд хөгжимчин, дуучин, бүжигчдийг ямагт дагуулж явдаг байжээ. Тэгэхдээ заримдаа бүр том хэмжээний хөгжмийн аги болон хөгжимт бүжгийн бүлгэм зохион байгуулдаг байсан байна.

Жишээнь, Чингис хааны дөрвөн хүлэг баатарын нэг болох Мухулай Алтан улсыг довтлох аянаа бүжигчин охидын тусгай баг бүрдүүлж хөгжимт бүжиг бүжиглүүлж байсан гэх мэдээ бий. Энэ тухай Сүн улсын элч Жо Хун “Монгол татарын тухай бүрэн тэмдэглэл”-дээ “...Мухуай дайнд мордохдоо 17, 18 настай маш сэргэлэн охидыг дагуулж явмой. Тэд төрийн их хөгжмүүдийг чавхдахын хамт, гараа алгадаж, хэмжээ хэмнэлийг цоглог болгоно, тэдний дуу нь маш богино, бүжиглэх нь маш гайхалтай...” [17.145] гэж бичсэн байдаг нь үүний нэг бримт. Мухулайн цэргийн доторхи хөгжимт бүжгийг “Маш гайхамшигтай” гэж хэлснээс үзвэл эртний монгол цэргүүд өөрсдийн онцлог, сүр жавхааг илэрхийлсэн өвөрмөц, лавтайяа Сүлүлсынхаас ялгагдах хөгжимт бүжигтэй байсан нь илт байна.

Монголчууд аян дайнд мордохынхоо өмнө “Тугаа сацах” /тайх/ их ёслол үйлддэг ба түүнээс гадна яг тулалдаанд орохынхоо өмнө бас цэрэг эрсийнхээ сэтгэл зоригийг чангалж мөнх тэнгэрээ даатгах өвөрмөц ёслол хийдэг, тэр бүхэнд хөгжим заавал оролцдог эртний заншилтай бйжээ. Монгол цэрэг тулалдааныг дайны хэнгэргийн дуунаар дохиолон эхлэх ёстой бөгөөд дайны хэнгэрэг дэлдэхээс өмнө “Дуу дуулан хоёр чавхдаст хөгжмөө намуухан татаж хөгжидөн тулалдааныг хүлээдэг байжээ [18.87].

Их Юань улсын үед дуу хөгжмийн урлагийг цэргийн хэргээс гадна төрийн хүндэтгэл ёслолын зорилгоор онцлон хөгжүүлж байв. Хубилай хаан Монголын их хаанаар өргөмжлөгдөөд улсаа “Их Юань” /Хөх тэнгэрийн улс гэсэн утгатай/ гэж нэрийдсэний дараа ордны хөгжмийн тусгай ангийг байгуулж, хаан төрийн ёслолд хэрэглэж байхаар шийдвэрлэжээ. Мөн өмнө нь цэргийн бүжиглэл, ордны хөгжмийн хороо гэж байсныг өргөтгөн хөгжимчид, хөгжмийн зэмсгийг нэмж байсан. Ингэхдээ хуучин хөгжимчдийг хэвээр сургах, хөгширч тэнцэхгүй болсоныг түүний үр хүүхдээр нь төлөөлүүлэн сургах, эс хүрэлцэхүйг нь бусад иргэнээр төлөөлүүлэх, хөгжмийн зэмсэг, ёслолын хувцас зэргийг үйлдүүлэх... тухай тушаал, зарлигийг гаргаж байжээ. Ингэснээр 412 хүний бүрэлдэхүүнтэй их найрал хөгжмийг [19.17] төрийн ёслол хүндэтгэлийн ажиллагаанд эгшиглүүлж байсан байна.

Ингэж Монголын ихэс дээдэс, хаад ноёд аялгуу хөгийн асуудал буюу уламжлалт хөгжмийн урлагтаа анхаарч түүнийг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар иржээ. Мөн XIII-XIV зууны Их Монгол Улсын үед цэрэг дайны хөгжим эрчимтэй хөгжсөн, дайн тулааны үед цэргийн хөгжмийг өргөн ашиглаж байсан, хөгжим, соёлыг хөгжүүлэхэд Чингис хаан, түүний үе залгамжлагчид ихэд анхаарч байсан зэрэг нь олон зүйлээр батлагдаж байна.

Ийнхүү хөгжим, түүний дотор цэргийн хөгжим хөгжиж ирсэн нь аяндаа урсгалаараа бүтсэн хэрэг биш бөгөөд дайн байлдааны үед цэргүүдийг эмх цэгцтэй нэгэн зохион байгуулалтад оруулах, дайчдын сэтгэл санаанд дэмжлэг үзүүлэх нь ялалтын гол шалтгаан болж байсан учир энэ нь төрийн ухаалаг мэргэн бодлогын хэрэгжилт байсныг түүх нотолж байна.

Abstract

This article tells about a history of use military brass band in military actions at Great Mongolian Empire, about revival of the first wind orchestra in Mongolia, about a role of a wind orchestra in the Mongolian culture and military art. Also it considers features of development of a military brass band of Mongolia from the point of view of a history, and tells about psychological impact of the music on soldiers.

Key words: music, military music, warlord, general, army commander, state hymn, military brass band, musical instrument, wind and percussion instrument.

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

Эшлэл, зүүлт

1. Моголын хөгжим судлал. 1989., 157 дахь тал
2. <http://www.wikipedia.org/w/index.php.title.action=history>
3. Кленв.А.С. Я познаю мир. Детская энциклопедия. Музыка. М., 1999., Стр 30.
4. Эрдэнэчимэг Л. Нүүдэлчдийн балар эртний үеийн дуу хөгжим. УБ., 2001. ...дахь тал.
5. Содом Б. Монгол дууны түүхээс. 1960. УБ., 5 дахь тал
6. Хөгжлт. Монгол үндэстний дуу хөгжмийн түүх. Өвөр Монгол. 1997. 245 дахь тал
7. Сүхаатар Г. Монголын эртний түүх судлал. I боть. УБ., 2000. 135 дахь тал.
8. Могол улсын шинжлэх ухаан. 22. УБ., 2009. 32 дахь тал.
9. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. 1966., 108 дахь тал.
10. Дагдорж Д. Цоодол Б. Ардын дуу хөгжмийн суу билэгтнүүд. УБ., 1971. 12 дахь тал.
11. Могол улсын шинжлэх ухаан. 22. УБ., 2009. 40-46 дахь тал.
12. Бадах Г. Монголын хөгжмийн түүхээс. УБ., 1960. 9-10 дахь тал.
13. Мако Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987. 88 дахь тал.
14. Шалдай Х. Чингис хааны онгон шүтээний тайлга, тахилга. УБ., 2001. 44 дэх тал
15. Бадаа Ж. Монгол ардын хөгжим. УБ., 1998. 133.153 дахь тал
16. Дагжаргал Л. “Нуман хуур” өгүүллийн гар бичмэл. УБ., 2009.
17. Могол Татарын тухай бүрэн тэмдэглэл. Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд хологдох хятад хоёр сурвалж. УБ., 2005. 145 дахь тал.
18. Мако Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987. 87 дахь тал
19. Дагдорж Д. Цоодол С. “Ардын дуу хөгжмийн суу билэгтнүүд. УБ., 1970. 17 дахь тал.